



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/25

Зуунмод

Сувилахуй, эх барихуйн чиглэлээр
хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/15 дугаар тушаал, 2020 оны А/139 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2020 оныг “Сувилагч, эх баригчийн жил” болгон зарласантай холбогдуулан 2020 оны 05 дугаар сарын 05-нд Олон улсын эх баригчдын өдөр, 05 дугаар сарын 12-нд Олон улсын сувилагчдын өдрийг “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхийг Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

2. “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг” сэдвийн хүрээнд арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, “Сувилахуй, эх барихуйн тусламж, үйлчилгээний чиглэлээр 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хоёрдугаар, аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааны зардлын төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тушаалын хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын төсвийг байгууллага бүр батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж, үр дүнг тооцон, хугацаанд нь тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтийг хангахад шаардлагатай хавсралтаар батлагдсан зардлын төсөв / Дөрвөн сая долоон зуун жаран долоон мянган төгрөг /-ийг хөтөлбөр төслийн зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Төмөрчөдөр/-д үүрэг болгосугай.

5. Уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Б.Энхтуяа/-г даалгасугай.

ДАРГА

С.МӨНХТУЯА



My doc: -/2020 on/ Tushaal A-4

410109

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
03 дугаар сарын 22-ны өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**“БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТАД СУВИЛАГЧ, ЭХ
БАРИГЧИЙН ҮҮРЭГ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

1. Үндэслэл:

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Гүйцэтгэх зөвлөлийн 2019 оны I сард хуралдсан 144 дэх хуралдаанаар эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн асуудлыг хэлэлцээд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд сувилагч, эх баригчдын үүргийг цохон тэмдэглээд, “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт” болон “Тогтвортой хөгжлийн зорилт”-ыг хэрэгжүүлэх гол хүний нөөц мөн гэж үзсэн.

Мөн Женев хотноо хуралдсан Дэлхийн эрүүл мэндийн 72 дугаар ассемблейгаас 2020 оныг “Сувилагч-эх баригчийн жил” болгон зарлан, эдгээр мэргэжилтнүүдийн хувь нэмрийг улам тодорхой болгох, хүний нөөцийн хомсдлыг бууруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэх, 2020 оны Дэлхийн эрүүл мэндийн өдрийг сувилагч, эх баригчийн үйл ажиллагааг дэмжих хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэхээр шийдвэрлэсэн.

Манай улсын хувьд сувилагч, эх баригчдын хүний нөөцийг нэмэгдүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажиллах орчин нөхцлийг сайжруулах, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд төр, хувийн хэвшлийн бүх шатны байгууллагын хамтын оролцооны хүчинд үйл ажиллагааг чиглүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамнаас уриалсан.

Манай аймгийн эрүүл мэндийн салбарын хэмжээнд сувилагчийн хүний нөөц дутагдалтай, сувилагч, эх баригчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага тавигдаж байна.

2. Зорилго: Сувилагч, эх баригчийн мэргэжлийн үйл ажиллагааг дэмжих

3. Зорилт:

1. Сувилагч, эх баригчийн хүний нөөцийг нэмэгдүүлэх
2. Сувилагчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах
3. Нийгмийн тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах
4. Сувилагч, эх баригчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалт, онол практикийн бага хурал, бусад арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах
5. “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг” сэдэвт өдөрлөгийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд зохион байгуулах
4. **Зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө:** Эрүүл мэндийн байгууллага, сувилахуйн алба, багууд салбарын хэмжээнд боловсруулсан төлөвлөгөөний хүрээнд болон өөрсдийн санал санаачлагаар өвөрмөцөөр хийх арга хэмжээгээ төлөвлөн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллана.
5. **Санхүүжилт:**
 - ЭМГазраас салбарын хэмжээнд зохион байгуулах арга хэмжээний зардлыг хөтөлбөр, төслийн зардлаар шийдвэрлэнэ.

- Эрүүл мэндийн байгууллагууд улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр, хандив, тусламжаар зохион байгуулах

6. Дүгнэж, урамшуулах:

1. Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг эрүүл мэндийн байгууллагуудаас сувилагч, эх баригчийн өдөр угтсан арга хэмжээний тайланг 2020 оны 05 сарын 04-ны дотор авч нэгтгэн дүгнэнэ.
2. Үзүүлэлт тус бүрээр 0-5 оноогоор дүгнэж, нийлбэр онооны дүнгээр байр эзлүүлнэ.
 - Нэгдсэн эмнэлгийн тасаг, нэгжүүдийн дунд 3 байр, Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн дунд 3 байр, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын дунд 3 байр тус тус эзлүүлэн дүгнэж, урамшуулна.
3. 2020 оны Сувилагч, эх баригчийн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн турш хийсэн арга хэмжээний тайланг 2020 оны 10 сарын 15-ны дотор ирүүлж, аймгийн Эрүүл мэндийн салбарын ажил дүгнэх үзүүлэлтэд оруулан байр эзлэлтэд тусган дүгнэнэ.

---oOo---

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
03 дугаар сарын 15-ны өдрийн
дугаар тушаалын хоёр дугаар хавсралт

**“БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТАД СУВИЛАГЧ, ЭХ
БАРИГЧИЙН ҮҮРЭГ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Зохион байгуулах, хамтран ажиллах байгууллага	Дүгнэлт/ Хүрэх үр дүн
1	Эрүүл мэндийн байгууллага бүр сувилагч-эх баригчийн жилийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нийтлэг болон өвөрмөц төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган, тодорхой үр дүнд хүрсэн байх	Жилдээ	АНЭ ӨЭМТ СЭМТ ХХЭМБ-ууд	2020 оны 06 сарын 15, 10 сарын 15-ны дотор ЭМГазрын ЭТХэлтэст хүрсэн үр дүнг тооцсон тайланг ирүүлсэн байна.
2	Эрүүл мэндийн байгууллага бүр сувилагч, эх баригчийн хүний нөөцийг нэмэгдүүлэх, ажлын ачаалал тэнцвэржүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж бодит үр дүнд хүрсэн байх	Жилдээ	АНЭ ӨЭМТ СЭМТ ХХЭМБ-ууд	Сувилагч, эх баригчийн хүний нөөцийг нэмэгдүүлэн, ажлын ачаалал тэнцвэржүүлж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулан бодит үр дүнг тайлагнасан байна.
3	Сувилагч, эх баригчдын эрүүл мэнд, нийгмийн байдалд судалгаа хийж дэмжлэг үзүүлэх аяныг өрнүүлэх	1-5 сард	АНЭ ӨЭМТ СЭМТ ХХЭМБ-ууд	Суурь судалгаатай болж, эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн тайланг 05 сарын 12-ны дотор ЭМГазарт ирүүлсэн байна.
4	Дэлхийн эрүүл мэндийн өдөрт зориулсан “Сувилагч- эх баригчдын нэг өдөр” буюу “Өглөөн нарнаас үдшийн бүрий хүртэл” сэдэв баримтат кино хийх	3 сарын 17-ноос 4 сарын 07-нд	ДЭМБ МСН ЭМГ Архуст СЭМТ	Сувилахуй, эх барихуйн тусламж үйлчилгээ анхан шатанд хэрхэн хүрч байгааг сурталчилсан кинотой болж, мэдээллийн хэрэгслээр цацагдсан байна.
5	Дэлхийн эрүүл мэндийн өдрийг “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг” уриан дор аймаг, сумандаа зохион байгуулах	04 дүгээр сарын 07	АНЭ ӨЭМТ СЭМТ ХХЭМБ-ууд	Сувилагч- эх баригчдын үйл ажиллагааг сурталчилсан, тайланг зурагжуулан 04 сарын 08-ны өдөр ЭМГ-ын ЭТХэлтэст ирүүлсэн байна.
6	Сувилагч, эх баригч, сувилахуй, эх барихуйн тусламж, үйлчилгээ, шинэ санаачлага, тэргүүн туршлагыг сурталчилсан /5 минут/ видео бичлэг, зохиомжийг шалгаруулах	04 дүгээр сарын 07-ны дотор	АНЭ ӨЭМТ СЭМТ ХХЭМБ-ууд	ЭМБайгууллагууд ЭМГазарт 2020 оны 04 сарын 07-ны дотор бичлэг, зохиомжоо ирүүлсэн байна.
7	Эрүүл мэндийн байгууллага бүр сувилагч эх баригчдад зориулсан	04 дүгээр сард	АНЭ ӨЭМТ	Уулзалт зохион байгуулж, тулгамдсан

	уулзалтыг аймаг, сум, байгууллагын удирдлагуудыг оролцуулан зохион байгуулж, тулгамдсан асуудлаа хэлэлцүүлж, шийдвэрлүүлэн үр дүнд хүргэсэн байх		СЭМТ ХХЭМБ-ууд	асуудлаа хэлэлцэн шийдвэрлүүлсэн байна. тайланг 04 сарын 24-ны дотор ЭМГ-ын ЭТХэлтэст ирүүлсэн байна
8	Орон нутгийн мэдээллийн хэрэгслээр “Сувилагч- эх баригч” мэргэжлийг сурталчлах, аймаг орон нутагт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг сурталчлах нэвтрүүлэгт бэлтгэн, зохион байгуулах	04 дүгээр сарын 22-29	АЗДТГазар НБХэлтэс ЭМГазар АНЭмнэлэг	Нэвтрүүлгийг үр дүнтэй зохион байгуулж, мэдээллийн хэрэгслээр цацагдсан байна.
9	Олон улсын сувилагч, эх баригчдын өдрийг “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх	05 дугаар сарын 05-12-ны өдрүүдэд	АНЭ ӨЭМТ СЭМТ ХХЭМБ-ууд	Сувилагч, эх баригчдын үйл ажиллагааг сурталчлан, алдаршуулах, урамшуулах өдөрлөгийг зохион байгуулсан тайланг 05 дугаар сарын 11-нд ЭМГазарт ирүүлсэн байна.
10	Аймгийн эрүүл мэндийн салбарын хэмжээнд сувилагч, эх баригчдын өдрийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	05 дугаар сарын 05-12-ны өдрүүдэд	АЗДТГ, ЭМГ, АНЭ	Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулагдаж, сувилагч, эх баригчдыг алдаршуулан урамшуулсан байна.
11	Сувилагч, эх баригчдаа дэмжин, олон улсын болон дотоодын хурал, семинарт оролцуулах	Жилдээ	АНЭ ӨЭМТ СЭМТ ХХЭМБ-ууд	Гадаад, дотоодын хурал, семинарт төлөөлөл оролцсон байна.
12	Сувилагч, эх баригч, тусгай мэргэжилтнүүдэд зориулсан мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх “Сувилахуй, эх барихуйн эмнэл зүйн онол дадлагын сургалт” зохион байгуулах	4-5 дугаар сард	ЭМГазар АШУҮИС Сувилахуйн сургууль, Төрийн болон ТББ, нийгэмлэг, холбоо	ЭМбайгууллагууд сувилагч, эх баригч, тусгай мэргэжилтнүүдээ сургалтад хамруулан, багц цагийг хангасан, байх, тайлан, үр дүн, оролцоог харгалзан дүгнэнэ.
13	“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлагыг төлөвшүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж сувилагч, эх баригч, тусгай мэргэжилтнүүдийг хамруулах	4-5 дугаар сард	ЭМГазар АШУҮИС Сувилахуйн сургууль, Төрийн болон ТББ, нийгэмлэг, холбоо	ЭМбайгууллагууд сувилагч, эх баригч, тусгай мэргэжилтнүүдээ сургалтад хамруулан, багц цагийг хангасан, байх, тайлан, үр дүн, оролцоог харгалзан дүгнэнэ.
14	Аймгийн сувилагч-эх баригч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд зориулсан “Онол практикийн бага хурал” зохион байгуулж дүгнэж урамшуулах	04-05 дугаар сард	ЭМГазар АНЭмнэлэг ӨЭМТ СЭМТ ХХЭМБ-ууд	ЭМБайгууллага бүрээс сувилагч, эх баригч, тусгай мэргэжилтний судалгааны илтгэл тавигдсан байна.
15	Эх барихуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шинэ туршлага болох “Гэр үнэлгээний аргачлал” болон “Масс мессеж	Жилийн турш	ЭМГазар АНЭмнэлэг ӨЭМТ СЭМТ	ЭМБайгууллагуудад нэвтэрч тодорхой үр дүнд хүрсэн тайланг 2020 оны 10 сарын 15-

	үйлчилгээ"-г нэвтрүүлэн үр дүнг тооцож, тайлагнах		ХХЭМБ-ууд	ны дотор ЭМГазарт ирүүлсэн байна.
16	Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын "Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг", 2020 оны сувилахуй, эх барихуйн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний нэгдсэн тайланг хүрсэн үр дүнг тооцож ирүүлэх	10 дугаар сарын 15-ны дотор	АНЭмнэлэг ӨЭМТ СЭМТ ХХЭМБ-ууд	ЭМБ-ын 2020 оны сувилахуй, эх барихуйн чиглэлээр төлөвлөсөн үйл ажиллагааны үр дүн, тайланг ЭМГазарт 10 сарын 15-ны дотор ирүүлсэн байна.
17	ЭМБайгууллагуудын сувилахуй, эх барихуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт, үнэлгээ хийж зөвлөн туслах	Хагас бүтэн жилээр	ЭМГазар ЭМБайгууллагууд	Сувилахуй, эх барихуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмж сайжирсан байна.
18	ЭМГазраас зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон оролцоо, урианы жилээр зохион байгуулсан үйл ажиллагаа, хүрсэн үр дүнгээр бүтээлч аян, дүгнэж байр эзлүүлнэ.	11 сарын 1	ЭМГазар	Жилийн турш хийсэн ажлыг ажлын хэсэг байгуулан дүгнэж байр эзлүүлэн, урамшуулсан байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
03 дугаар сарын 12 -ны өдрийн
дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**“СУВИЛАГЧ, ЭХ БАРИГЧИЙН ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН
БАЙГУУЛАГДАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын төрөл		Хэмжих нэгж	Тоо, ширхэг	Зардал /төгрөг/-өөр	
					Нэг бүрийн	Бүгд
1	“Сувилагч-Эх баригчийн өдөр” өдөрлөг	Урианы жилийн зар	М ²	4x4	6.500	104.000
2		Хөгжим аппаратур	Хүн/өдөр	1/1	100.000	100.000
3		Гарын авлага, амин дэм,	Хүн	500	800	400.000
Бүгд						604.000
4	“Сувилахуй, эх барихуйн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулья” сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд зориулсан багц цагийн сургалт	Багш нарын хоол	Хүн/өдөр	5x3	12,000	180.000
5		Цай, кофе	ширхэг	300x3	500	450.000
6		Печень	ширхэг	300x3	1000	900.000
Бүгд						1.530.000
7	Бүтээлч аяны урамшуулал	Өргөмжлөл	Ширхэг	9	60.000	540.000
8		Шүүгчдийн үйл ажиллагааны зардал	Хүн	5	20.000	100.000
9		1-р байр шагнал /АНЭ, ӨСЭМТ, ХХЭМБ/	Хамт олон	3	Цалингийн 25%	1сар
10		2-р байр шагнал /АНЭ, ӨСЭМТ, ХХЭМБ/	Хамт олон	3	Цалингийн 20%	1сар
11		3-р байр шагнал /АНЭ, ӨСЭМТ, ХХЭМБ/	Хамт олон	3	Цалингийн 15%	1сар
Бүгд						640.000
12	“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг төлөвшүүлэх нь” эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалт /багц цагийн/	Багш нарын хоол	Хүн/өдөр	2 хүн /2 өдөр	4x15,000	60,000
		Цай, кофе		ширхэг	200x4	500
		Печень	ширхэг	200x4	1000	800,000
Бүгд						1,260.000
13	Онол практикийн бага хурлын шагнал, үйл ажиллагааны зардал	Өргөмжлөл	ширхэг	4	60.000	240.000
14		1-р байр шагнал	Хүн	1	150.000	150.000
15		2-р байр шагнал	Хүн	1	120.000	120.000
16		3-р байр шагнал	Хүн	1	100.000	100.000
17		Уран илтгэгч	Хүн	1	80.000	80.000
18		Цэвэр ус	ширхэг	15	600	9.000
19		Жүүс	ширхэг	6	1.500	9.000
		Тавгийн чихэр	кг	1	25.000	25.000
Бүгд						733.000
НИЙТ						4.767.000